

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Боть XXXIX (433)

2015

(37-43)

МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛЬ БА ТӨРӨӨС БАРИМТЛАХ
ХЭЛНИЙ БОДЛОГЫГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ АСУУДАЛД
/1990-ээд оноос хойш/

Ч. Баттулга *

Түлхүүр үг: Төрийн бодлого, хэлний бодлого, монгол хэлний тухай хууль, монгол хэл бичгийн сургалт, үндэсний бичиг, кирил үсэг.

Товч агуулга: “Монгол хэлний тухай хууль” батлагдсан нь хэлний талаарх төрийн бодлогод тодорхой дэвшил гарсан ч цаашид улам бүр тодорхой, оновчтой болгох зарим зүйл байна. Мөн монгол бичгийг “устгах” УИХ-ын 1994 оны 66-р тогтоол гарах болсон гадаад дотоод шалтаг, шалтгааныг олж тогтоох, улмаар ийм “хор хөнөөл”-тэй шийдвэр давтан гаргуулахгүй байх талаар онцгой анхаарах ёстой.

Аливаа Төрийн бодлогын салшгүй чухал хэсэг нь хэлний бодлого байдаг бөгөөд тухайн улс орны хэлний асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үзэл суртлын зарчим, практик ажлын нэгдлийг хэлний бодлого гэдэг. Хэлний бодлого хэлний хэрэглээ, хэлний үзэл суртал, хэлийг удирдах, төлөвлөх, хөндлөнгөөс оролцох замаар хэлний хэрэглээнд нөлөөлөх гэсэн гурван хэсгээс бүрэлдэнэ/Spolsky/¹. Төрийн хэлний бодлогод Үндэсний хэлний гадаад, дотоод бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, тухайн улсын үндэсний болон албан ёсны хэлний статусыг тогтоох, эх хэл, үсэг бичгийг сонгох, хэрэглэх, хэрэгжүүлэх, хос хэл, олон хэл, цөөнхийн хэлний хэрэглээний таатай, зөв зохистой нөхцөл бүрдүүлэх, хүний хэлний эрх, хэлний өвийг хамгаалах, хэлний хууль, дүрэм журам боловсруулах, амьдралд хэрэгжүүлэх, хэлний хэм хэмжээ тогтоох, зөв бичих дүрмийг боловсронгуй болгох, шинэ үг, нэр томъёо тогтоох, жигдрүүлэх, мөрдүүлэх, хэвшүүлэх, бүх шатны сургалтын стандарт хөтөлбөр, сурах бичиг, лавлагаа, толь бичиг зохиох, бүх төвшний орчуулгын асуудал, хэл заах арга, сургалтын технологи, хэлний соёл-харилцааны асуудал, олон нийтийн хэвлэл мэдээлэл, нийтлэл, сонин сэтгүүлийн найруулга, гадаад хэлний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх гэх мэт өргөн цар хүрээтэй асуудлыг багтаадаг.²

* МУИС, Шинжлэх ухааны сургууль, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

¹ Ч.Зэгиймаа, *Даяаршил ба хэлний бодлого*, Монгол улсын хэлний бодлого, Улаанбаатар, 2006, 16-р тал.

² Ч.Зэгиймаа, *Эх хэл, үсэг бичгийн талаархи төрийн бодлого*, Монгол улсын хэлний бодлого, Улаанбаатар, 2006, 134-р тал.

Манай Улсын хувьд, 1990 оны 6 дугаар сарын 1-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоол гарснаар монгол бичгээ сэргээх асуудал Монголын Төр, Засгийн үйл хэрэг болж эхэлсэн байна³. Мөн 1991 онд “БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэл ажлыг хангах тухай” Улсын Бага Хурлын 36 дугаар, “БНМАУ-д албан хэргийг 1994 оноос монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах тухай” Засгийн газрын 186 дугаар тогтоол, 1992 онд “Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай” Монгол улсын Засгийн газрын 68 дугаар тогтоол тус тус гарч байсан нь монгол хэл бичгийн талаар явуулж байсан Төр, Засгийн бодлогын чухал хэсэг байлаа. Улмаар 2003 оны 5 дугаар сарын 15-нд 3 бөлөг 8 зүйл бүхий “Төрийн албан ёсны хэлний хууль” батлан гаргав.

Ийнхүү монгол хэл бичгийн талаархи Төрийн бодлого өнөө хүртэл үргэлжилж ирсэн ч уг ажлыг эрчимжүүлэх, монгол хэлний бодлогын гол гол асуудлыг тодорхойлох, хэлний бодлогыг эрдэмтэн судлаач нарын хүчээр шинжлэх ухаанчаар боловсруулах зэргээр уг асуудлыг шинэ шатанд гаргах хэрэгцээ шаардлага байсаар байв.

Хэлний Бодлогын Үндэсний Академиас “Төрөөс баримтлах хэлний бодлогын асуудал” (2005, 2006), “Монгол Улсын боловсролын салбарын хэлний бодлого” (2007), “Даяаршлын үеийн үндэстний гадаад хэлний бодлого” (2007), “Даяаршил ба Төрөөс баримтлах хэлний бодлого” (2007) зэрэг цуврал хурал зохион байгуулсан бөгөөд тэндээс гарсан, манай хэл бичгийн эрдэмтэн судлаачийн үнэ цэнтэй санал санаачлагыг тусгасан зөвлөмж Төрөөс баримтлах хэлний бодлогыг тодорхойлох үндэс суурь болсон төдийгүй 2015 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөх 8 бөлөг 24 зүйл бүхий “Монгол хэлний тухай” хууль батлахад ихээхэн түлхэц болсон нь дамжиггүй. Тухайлбал:

1. “Төрийн албан ёсны хэлний хууль”-ийг өөрчилж, “Монгол хэлний хууль” цогц байдлаар гаргаж мөрдөх (Төрийн хэл гэж байхгүй түмний хэл гэж байна - Л.Түдэв)

2. “Төрийн хэлний зөвлөл”-ийг өргөтгөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэл болон гадаад хэлний бодлогыг нягт уялдаатай боловсруулах (монгол хэл болон гадаад хэлний салбар зөвлөл бүхий) “Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл” байгуулах

3. Үсэг бичгийн хэрэглээ, хэлний дүрэм журмыг нэг мөр болгон эцэслэн шийдвэрлэж, нийтээр даган мөрдүүлэх

4. Монгол бичиг, кирил үсэг, латин үсэг, гадаад хэлний хөтөлбөрийг харилцан шүтэн барилдсан нэгдмэл бодлогын төвшинд хэрэгжүүлэх

5. Бүх шатны сургалтын стандарт, хөтөлбөрийг мэргэжлийн ихээхэн чадвартай хүнийг олноор оролцуулан шинэчлэн боловсруулах, эрдэмтэн судлаач нараар экспертиз хийлгэх

6. Шинжлэх ухааны шинэлэг чиглэлийн судалгааг хүчтэй болгох замаар монгол хүнд хэл заах шинэ технологи боловсруулах, эх хэл, гадаад хэлний сургалтыг явуулах үндэслэлийг зөв тогтоох

7. Эрдэмтэн судлаач нарын хүчийг түлхүү ашиглан, гадаад хэлний концепц боловсруулах, хос болон олон хэлтэй байх орчинг бүрдүүлэх... зэрэг асуудлыг Монгол

³⁾ Д.Лхагвасүрэн, Г.Буянтогтох, Л.Чулуунбаатар, Монгол бичгийн нийгмийн үүрэг, Улаанбаатар, 2013, 118-р тал.

Улсын Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газарт хандан удаа дараа тавьж байсны үр дүнд уг хуульд тодорхой биеллээ олсон гэж болно.

Ерөнхийлөгчийн дэргэдэх “Хэлний Бодлогын Үндэсний Зөвлөл” кирил болон үндэсний бичгийн зөв бичих дүрмийг боловсронгуй болгон, бүх нийтээр нэг мөр даган мөрдөх, нэр томъёог оновчтой орчуулан, монгол хэлний үгийн санд оруулах, шинэ нэр томъёог хэлэлцэн батлах, газар нутаг, гудамж, зам талбайд гадаад нэр өгөх эсэх асуудлыг шийдвэрлэх, Төрийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага монгол хэлний хэм хэмжээг баримталж байгаа эсэхийг хянаж, дүгнэх зэрэг хэлний бодлогын асуудлыг хуулиар зохицуулжээ.

Аливаа хууль Төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх гол бичиг баримт болдогийн хувьд өнөөгийн Монгол Төрийн хэл бичгийн талаар баримталж буй бодлого “Монгол хэлний тухай” хуульд туссан гэж ойлгож болно. Нөгөөтэйгүүр, Монгол хэл бичгийн салбарын эрдэмтний оролцоотойгоор боловсруулсан “Монгол хэлний тухай” хууль бол хэлний талаархи Монгол Төрийн бодлогын цөм юм⁴.

Ийнхүү хууль батлагдсан нь томоохон дэвшил болсон ч “Монгол хэлний тухай” хуульд хэлний бодлогын зарим чухал асуудлыг тодорхойгүй орхисон, бүрхэгдүүлсэн тал байна. Үүнд:

Нэгд. “Монгол хэлний тухай” хуулийн 2-р бүлэг.

Монгол хэлийг хэрэглэх

6.1.2 Төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг байгууллагаас бусад боловсролын байгууллагын сургалт...

6.3.Төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд гадаад хэлийг тавдугаар ангиас эхлэн заана...” гэжээ⁵.

Энэ заалтаар, Сургалтад онцгой өөрчлөл гарахгүй, хуучин хэвээр байна. Харин тусгай зөвшөөрлөөр гадаад хэлний сургалт явуулдаг сургууль (голдуу Төрийн бус өмчийн сургууль) 1-р ангиас гадаад хэл заана. Бусад сургууль (голдуу Төрийн өмчийн, хөдөө орон нутгийн) 1-р ангиас заах боломжгүй болох аж. Үүнээс үзвэл, унаган хэлний асуудал биш эд хөрөнгө, улсын ба хувийн хэвшил, оршин суугаа газраас хамааран, хүүхдийн эрх тэгш сурах боломжийг хязгаарласан, ёс төдий заалт болон хувирчээ.

Уул нь, хүүхдэд 12 нас хүртэл зөвхөн унаган хэлийг эзэмшүүлэх ёстой гэдэг санаа (заалт) уг хуулийн “амь сүнс” байв. Мөн “ЕБС-ийн 1-5 дугаар ангид ямар нэгэн гадаад хэл, бусад бичиг үсэг заахгүй байх эрхзүйн шийдвэр, гаргаж хэрэгжүүлэхийг”⁶ хүсч байсан ч ийнхүү талаар болов.

⁴) Монгол хэлний тухай хуулийн 5-ын 2-т: *Монгол хэл, бичиг үсгийг эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг хангах нь төрийн үүрэг мөн* гэж заажээ.

⁵) Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5-ын 13-т *Бүх шатны боловсрол олгох сургалтын төрийн албан ёсны хэлээр явуулна. Энэ заалт үндсэн ба мэргэжлийн сургалтаа гадаад хэлээр явуулдаг сургалтын байгууллагад үл хамаарна* гэж байв. 2002 онд шинэчлэн найруулсан Боловсролын тухай хуулиар бага дунд боловсролын 11 жилийн сургалтын төлөвлөгөөнд Англи хэлийг 5-р ангиас заахаар тусгасан байсан.

⁶) Д.Төмөртогоо, Ц.Өнөрбаян, Б.Пүрэв-Очир, *Эх хэлний сургалтын өнөөгийн байдал, төрөөс эх хэлний талаар явуулах бодлого*, Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, Улаанбаатар, 2007, 8 тал

Монгол хүүхдэд нэлээд бага наснаас нь эхлэн гадаад хэл шууд заах нь зүйтэй, мөн монгол хэлээ эхлэн үзэж байж, тодорхой насанд хүрсэн үед нь гадаад хэл үзүүлэх нь зүйтэй гэсэн хоёр санал энд зэрэгцэн явж байна. Харин бага насны хүүхдэдээ гадаад хэл заах хүсэл эрмэлзэл аав, ээжийн дотор сүүлийн жилүүдэд эрс нэмэгджээ⁷. Аав ээжийн хүсэл сонирхолд хүндэтгэлтэй хандаж буй ч “Унаган хэл бол зөвхөн ярьдаг хэл биш, сэтгэдэг хэл юм. Тиймд унаган хэл муутай хүүхэд насан туршдаа бусдаас дутуу сэтгэдэг”⁸ болохыг судлаачид тогтоосныг анзааралгүй орхиж болохгүй.

Мөн хуулийн 7.3-д “Их дээд сургуульд элсэгчдээс монгол хэлний шалгалт, 13.1.3. Сурган хүмүүжүүлэх ухаан, уран зохиол, сэтгүүлзүйн чиглэлээр их дээд сургуульд элсэгчдээс монгол хэл бичгийн тусгай шалгалт авах” болсон нь бүх нийтийн монгол хэлний боловсролыг дээшлүүлэх талаар авч буй чухал арга хэмжээ боловч монгол хэл болон гадаад хэлний бодлогыг нягт уялдаатай боловсруулах тал дээр өрөөсгөл хандсан байна.

Монгол улс 1990-ээд оныг хүртэл хязгаарлагдмал гадаад харилцаатай, хүн амын гадаад хэлний хэрэгцээг үндсэндээ орос хэлээр хангагдаж байв. Харин 1992 оны Үндсэн хуулиар нээлттэй эдийн засаг, олон тулгуурт гадаад бодлогын зарчим тунхагласнаас хойш манай улсын улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын гадаад харилцаа өргөжиж, хүн ардыг хэлний хэрэгцээ ч өсөн нэмэгдэв.

Манай орны ерөнхий боловсролын сургуулиудад 1992-1993 оны хичээлийн жилээс англи хэлийг зааж эхэлсэн ба сургуулиудыг багшлах боловсон хүчнээр хангахын тулд орос хэлний багш нарыг нэг жилийн эрчимт сургалтанд хамруулж англи хэлний багш болгон бэлтгэжээ. Тухайн үед гадаад хэлний олон сургууль байгуулагдаж, дунд сургуулиудад дур дураараа гадаад хэлийг сонгон заах болсон замбараагүй байдлыг цэгцлэх зорилгоор Монгол Улсын Гэгээрлийн сайдын 1997 оны 7 дугаар сарын 25-ны “гадаад хэлний сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 208 тоот тушаалаар 1997-1998 оны хичээлийн жилээс эхлэн бүх шатны сургалтын байгууллагад гадаад хэлний сургалтаар англи хэлийг эхний ээлжинд заахаар зохион байгуулах шийдвэр гаргасан юм⁹.

1997 онд Гэгээрлийн сайдын тушаал гарч англи хэлийг албан ёсны гадаад хэл болгон боловсролын бүх түвшинд залгамж холбоотой, түлхүү судлуулах зорилтыг дэвшүүлсэн нь англи хэлний боловсролыг хөгжүүлэх чухал түлхэц болсон байна¹⁰.

2001 оны 12-р сард бүх шатны сургуулийн англи хэлний сургалтын агуулга, заах арга зүй, сурах бичгийг боловсронгуй болгох, англи хэлний багш нарын мэргэжил, хэлний болон заах аргын чадварыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор “Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.¹¹

Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 390 дүгээр тушаалаар баталсан “Монгол улсын Бакалаврын боловсролын стандартын үлгэрчилсэн загварт” төгсөгчийн

⁷⁾ Н.Бэгз, *Гадаад хэлний сургалтын бодлого*, Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, Улаанбаатар, 2007, 14-р тал.

⁸⁾ Судлаач Д.Энхбат

⁹⁾ Н.Бэгз, Д.Наран, Ж.Долгормаа, *Гадаад хэлний сургалтын өнөөгийн байдал цаашдыг зорилт*, Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, Улаанбаатар, 2007, 33-р тал.

¹⁰⁾ Н.Мира, ЕБС-ийн англи хэлний боловсролын түүхэн хөгжил, Боловсролын шинэчлэлийн онол арга зүйн асуудлууд, Улаанбаатар, 2006, 130-р тал.

¹¹⁾ Н.Бэгз, Д.Наран, Ж.Долгормаа, *Гадаад хэлний сургалтын өнөөгийн байдал цаашдыг зорилт*, Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, Улаанбаатар, 2007, 33-р тал.

гадаад хэлний бэлтгэлийг “Наад зах нь нэг гадаад хэлийг өдөр тутмын болон мэргэжлийн үйл ажиллагаандаа ашиглах чадвартай байх” хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл, тухайн үед аль нэг гадаад хэлийг онцолж нэрлээгүй, чухам ямар хэл голлох гадаад хэл болгохыг их, дээд сургуулийн мэдэлд үлдээсэн байв. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 481 дүгээр тушаалаар эл байдлыг өөрчилж, бакалаврын боловсролын агуулга дахь голлох гадаад хэл “англи хэл” болохыг нэр заан тодотгож, Англи хэлний хичээлийн агуулгын багтаамж 8 багц цагаас доошгүй байна, зорилго нь “Англи хэлний олон улсын дундаж төвшинтэй дүйцэх мэдлэг, чадвар олгоход чиглэнэ”, энэхүү хичээлийг судлах оюутны бэлтгэл англи хэлний олон улсын эхлэн суралцагчийн төвшний мэдлэг, чадвартай байна хэмээн тодорхойлсон байна.¹²

Энэ мэтчилэн гадаад хэлний талаарх төрийн бодлогын олон баримт бичиг гарч, тодорхой хэмжээгээр хэрэгжсээр байв.

Тэр ч байтугай, Монгол Улсын Их Хурлын 2008 оны 01 сарын 31-ний өдрийн “Монгол улсын мянганы зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” батлах тухай 12-р тогтоолд, Англи хэлний боловсролын цар хүрээ, хүрэх төвшинг доорх байдлаар тодорхойлж байв. Үүнд,

- 2015 онд багтаан англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгоно.

- 2015 он хүртэлх хугацаанд бүх нийтийн англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлнэ. Дээд боловсрол эзэмшигчид ажил, мэргэжлээрээ шаардлагатай мэдээллийг англи хэлээр ашиглах чадвартай болно.

- 2021 он гэхэд төрийн захиргааны төв байгууллагын ажилтнууд албан ажлаа англи хэлээр явуулах чадвартай болно гэж ч байжээ.

Харамсалтай нь, Уг хуульд/6.3/ *Төрөөс олгосон зөвшөөрөлтэй ерөнхий боловсролын сургуулиуд* 1-р ангиас гадаад хэлээр сургалт явуулна гэхээс өөр цаашид гадаад хэлний талаар төрөөс ямар бодлого барих, ялангуяа үндэсний хэл бичгийн бодлоготой хэрхэн уялдуулах талын зүйл заалт орхигдуулсан нь, эсрэгээр, монгол хэл бичгийн бодлогод сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.

Хоёрт, Хуулийн зарчим, үзэл баримтлалаас үзвэл, үндэсний бичиг үсгээ хөгжүүлэх зорилготой мэт боловч, үнэн хэрэгтээ, кирил үсгийг баталгаажуулсан хууль болохыг уг хуулийн “7.1.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээд албан хэргээ кирил бичгээр хөтлөн явуулна” гэсэн заалтаас түвэггүй ойлгож болно.

Төрийн хэлний зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 5-ны “Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай” 01 тоот тогтоол, Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 2-ын “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” 37 дугаар тогтоол зэргийг эс тооцвол өнөө хүртэл кирил үсгийг (БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хамтарсан 1941 оны 5 сарын 9-ны өдрийн 25/27-р хурлын тогтоолын 1-р заалт ...Орос үсгийг үндэслэн монгол үсгийг бүгд 35 үсгээр...баталсан, 1945 оны 5 дугаар сарын 18-ны дээрх хоёр том байгууллагын хамтарсан 31/27-р хурлын 1 заалтаар ...Бүх хэвлэл ба улсын албан хэргийг 1946 оны 1 сарын 1-нээс эхлэн шинэ үсгээр явуулсугай... гэсэн тогтоол) баталгаажуулсан, эс баталгаажуулсан ямар нэгэн хууль тогтоомж гараагүй байв.

¹²⁾ П.Батринчин, *Дээд боловсролын агуулга дахь гадаад хэлний төрийн бодлого*, Гадаад хэл, соёл, МУИС, ЭШБ, 2009, №314 (13), 160-р тал.

Гэсэн атал, Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна гээд, хөтлөх хугацааг 7.2-д “...үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр”, 11.1.2-заалтын дагуу Засгийн газар “Үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх” гэдгийг “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-I” 1995-2005, II 2008-2015, үргэлжлэн батлах (одоо батлаагүй) “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III” хэрэгжсэний дараа буюу наанадаж 2025 оноос гэж барагцаалж байна. Хугацаа тодорхой биш байна.

Монгол бичгийн сургалтын тухайд, уг хуулийн 7.3-д “Өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийн суралцагчдад үндэсний бичгийг 6-р ангиас эхлэн төгсгөл тусгайлсан хөтөлбөрөөр заана”. 7-ийн 4-т, “Их дээд сургуульд элсэгчдээс авах элсэлтийн ерөнхий шалгалт болон төрийн албанд анх орох иргэнээс авах монгол хэлний шалгалтын агуулгын дөрөвний нэгээс доошгүй хувь үндэсний бичгийн мэдлэгийг үнэлэхэд чиглэнэ” гэсэн заалтаас үзвэл монгол бичгийг бүх нийтэд сургах ажлыг дахин өрнүүлж буй нь сайн хэрэг боловч 1994¹³, 1998¹⁴, ялангуяа 1990-1994 оны үеийнх шиг монгол бичиг суръя гэсэн ард иргэдийн хүсэл тэмүүлэл, идэвх зүтгэл, үр дүн өнөө цагт эргэж олдоно гэдэг тун эргэлзээтэй. Дашрамд, монгол бичгийг “устгах” УИХ-ын 66-р тогтоол гараагүй бол одоо бид монгол бичигт нэгэнт шилжсэн, бичиг үсгийн асуудал шийдэгдсэн байх байлаа.

Гуравт, Аж ахуйн нэгж, иргэн “дан” бичгээр (одоо кирил) хэрхэн бичиж, албан бичиг хэргийг ямар төвшинд хөтөлж боловсруулж буй билээ, ийм үед давхар (хос) бичгээр албан бичиг хэрэг хөтөлнө гэдэг амаргүй хэрэг.

Уг хуулийн 13.1.4-д “Суралцагчийн дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулна” гэж заажээ. Манай оронд 103 мянган казак иргэн аж төрдөг бөгөөд тоогоороо халх үндэстний дараа орж, манай улсын хүн амын 4,3 хувийг эзэлдэг ажээ. Эдгээрийн 91 мянган хүн Баян-Өлгий аймагт суудаг. Казакууд өөрийн бичиг үсэгтэй бөгөөд энэ аймагт ЕБС монгол казак хоёр хэлээр албан хэргээ хөтлөн явуулдаг байна¹⁵. Хос хэлний үзэгдэл яах аргагүй Нийгэм хэлшинжлэлийн гол судлагдахууны нэг юм.

Харин хос бичгийн асуудал ихээхэн ярвигтай. Монголчууд бид улс төрийн болон бусад шалтгааны улмаас хос бичиг хэрэглэж байсан үе цөөнгүй бий. Ер нь хос бичиг хэрэглэнэ гэдэг тусгаар тогтносон улсын хувьд тийм ч эерэг зүйл биш юм.

Хэл болон бичиг үсэг зөвхөн нийгэмд байдаг үзэгдэл мөнийг, нийгэм нь улс төрийн бодлогын ачаар оршин тогтнодог учраас хэлний болон бичиг үсгийн асуудлыг нийгмийн улс төрийн бодлогоос ангид авч үзэх боломжгүйг ойлгож, бичиг үсэг болон ерөөс хэлшинжлэлийн аливаа асуудлыг судалж шинжлэх, шүүн хэлэлцэхэд улс төрийн

¹³⁾ УИХ-ын 66-р тогтоол.

¹⁴⁾ Монгол бичигт бүх нийтийг сургах асуудлыг албан бус сургалтын хүрээнд зохион байгуулж байсан 1996-1997 оны үед насанд хүрэгчдийн 80% хувь монгол бичиг сурч байсан бол 1998 оноос энэхүү сургалтын хамрах хүрээ жил ирэх тутам буурсан байна. БСШУЯ-ны Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын 2006 оны 8 сарын 7 нд гаргасан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний танилцуулга” баримт бичгээс.

¹⁵⁾ Т.Цэцэгмаа, Монгол улсын хэлний нөхцөл ба хос хэлний асуудал, Монгол улсын хэлний бодлого, Улаанбаатар, 2006, 101-р тал.

боловсролын дээд төвшнөөс хандаж байхын чухлыг гүнзгий ухамсарлах нь чухал байна¹⁶.

ДҮГНЭЛТ

1. Хэлний талаарх төрийн бодлогыг улам бүр тодорхой, оновчтой болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

- Монгол хүүхэд бүр 12 нас хүртэл зөвхөн унаган хэлээ эзэмшээд, 12 наснаас дээш аль нэг, түүнээс олон гадаад хэлийг чанартай сайн сурах /сургах/ орчин нөхцөл бүрдүүлэх, эрхзүйн шийдвэр гаргаж хэрэгжүүлэх

- Бүх шатны сургалт болон нийгмийн хэрэглээнд эх хэл хийгээд гадаад хэлний эзлэх байр суурийг зөв тодорхойлж, тэдгээрийг заах аргыг боловсронгуй болгох

- Монгол улсад албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах эсэх, явуулах бол тогтоол шийдвэрийн хугацааг тодорхой заах, хос бичгийн асуудлыг эргэн харах... зэрэг болно.

2. “Албан хэргийг монгол бичгээр хөтлөх бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлэх” тухай Монгол Улсын Засгийн газрын 64-р тогтоол 1994 оны 3 сарын 16-ны өдөр гарсан атлаа гуравхан сарын дараа буюу хаврын чуулганы сүүлчийн өдөр монгол бичгийг “устгах” 66-р тогтоол УИХ-аас гарсан нь санамсаргүй хэрэг биш бөгөөд гадаад дотоод шалтаг, шалтгааныг олж тогтоох, улмаар ийм “хор хөнөөл”-тэй шийдвэр давтан гаргуулахгүй байх талаар онцгой анхаарах ёстой.

SUMMARY

Having approved "The bill on the Mongolian language" was the certain advancement on the state policy about language. Although there are some issues on improving it more clearly and accurately. Also there is a need to define the intrinsic and extrinsic reasons 'to abolish' Mongolian script that was issued by the decree No.66 of the State Great Khural in 1994. Furthermore, there will have a greater attention not for re-issuing such 'adverse' decision.

¹⁶⁾ Д.Лхагвасүрэн, Г.Буянтогтох, Л.Чулуунбаатар, Монгол бичгийн нийгмийн үүрэг, Улаанбаатар, 2013, 118-р тал.